

Дундговь аймгийн Засаг даргын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай 2024 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 09

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Нийгмийн бодлогын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 84 үүргийг хүлээж, үүргийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажилласнаар эхний хагас жилээр үүргийн биелэлт 76.7 хавсралт гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 64.5 дундаж гүйцэтгэл 70.6 үнэлэгдсэн. Сүүлийн хагас жилээр үүргийн биелэлт 92.6 хавсралт гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 92.5, дундаж гүйцэтгэл 92.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, удаашралтай болон тасарч болзошгүй 11 заалтын жагсаалтыг гарган хэлтэс, агентлагуудад хүргүүлэн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар явцын хяналт-шинжилгээгээр агентлаг бүрд зөвлөгөө өгч ажилласны үр дүнд хийсэн ажлын үр дүн 21.9 хувиар ахисан үзүүлэлттэй байна.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын чиглэлээр

Гэр бүл, хүүхдэд сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх “явуулын үйлчилгээ”-г Монгол өрх хүрээлэнтэй хамтран 3 сумын төрийн албан хаагч, ахлах ангийн сургач нийт 280 хүнийг хамруулан зохион байгуулсан. Сургалтаар гэр булийн тогтвортой байдлыг хангах, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, үе тэнгийн дарамт, хүүхэд хамгаалал, бие биенийхээ ялгаатай байдлыг ойлгон хүлээн зөвшөөрөх зэрэг мэдлэг олгосон. Гэр бүл хосууд хоорондын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, эцэг эх, баг хамт олны дунд өөрийн үүрэг оролцоог хангах, өөрийн дотоод ертөнцрүү өнгийж өөртөө дүгнэлт хийх, өөрийгөө өөрчлөх, хүүхэд хамгаалалын үйлчилгээг сайжруулах, хамтарсан багт зөвлөгөө өгөх, үе тэнгийн дарамт, айдсыг хүүхдүүд өөрсдөө илчлэх, таслан зогсоох, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх мэдлэг авлаа.

Зарцуулсан төсөв: Улсын төсвөөс 6.242.300 зарцуулсан.



Сургалтын төгсгөлд авсан сэтгэгдлээс хараад багшийн өгсөн агуулгыг сайтар ойлгож авсан, ажлын байран дээрээ очиж хэрэгжүүлэхээр ярьж байгаа нь сургалт өмнөө тавьсан зорилгодоо хүрсэн байна. Цаашид бөглөсөн маягт нь ажлын байран дээрээ очоод кейс дээр ажиллахад жишиг кейс файл болох бөгөөд үйлчлүүлэгчдэд кейс менежментийн үйлчилгээг үзүүлэхэд дөхөм болно гэж харж

байна. Сургалтад оролцогчдын мэдлэг, оролцогчдын сэтгэгдлийг хавсралтаас харна уу. Мэдээний линк:

<https://www.facebook.com/share/p/6BTAQSjXznAD5bmg/?mibextid=oFDknk>

Сансрын 7 хоног арга хэмжээг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, UNITEL HUB, UNITEL салбар, Дундговь аймгийн Музей, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Төрийн бус байгууллагын сургагч багш Э.Мөнхжаргал, аймгийн Хүүхдийн зөвлөл, Сайн дурын хүүхдүүдтэй хамтран амжилттай зохион байгуулсан.

Тус арга хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 775, цэцэрлэгийн насны 180 нийт 955 хүүхдэд шинжлэх ухаан, сансар огторгуй судлаалаас бий болдог өндөр технологи, ашиг тусыг таниулж, сансрын ойлголт мэдлэгийг дээшлүүлж ажиллалаа.



Зарцуулсан төсөв: Улсын төсвөөс 2,770,000

Нийгмийн халамжийн чиглэлээр

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 270 өрхийн хөдөлмөрийн насны 728 иргэн байгаагаас хөдөлмөрийн чадвартай ажил хөдөлмөр эрхлээгүй 98 иргэний бүртгэл судалгааг гарган хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрууллаа. Үүний үр дүнд 51 иргэнийг байнгын ажлын байраар хангаж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс 8 өрхийг түдгэлзүүлж, Говь-угтаал сумыг хүнсний эрхийн бичиггүй сум болгосон. Аймгийн хэмжээнд 4 сум хүний эрхийн бичиггүй сум болоод байна.




Халамжаас-Хөдөлмөрт бодлогын хүрээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаад төсөл хөтөлбөрт хамрагдаж хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс татгалзсан 4 өрхөд зочилж сайн туршлагыг сурталчлах зорилгоор цуврал видеог бэлтгэн байгууллагын пэйж хуудас болон орон нутгийн зар мэдээний facebook групպүүдээр олон нийтэд сурталчлан ажиллалаа.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах чиглэлээр

Хөдөлмөр эрхлээгүй 1736 иргэн хөдөлмөр эрхлэлтийн ЕJOB програмд бүртгэгдсэнээс 567 иргэнийг байнгын ажлын байраар хангаж, ажилгүй иргэдийн тоог 32,7 хувиар буурууллаа. 2024 онд байнгын ажлын байранд 567, түр ажлын байранд 625, нийт 1192 иргэнийг ажилд зуучилж, үүнээс 312 шинэ ажлын байр бий болгосон.



Өмнө онд 3 улирлын байдлаар ажилгүйдлийн түвшин 6,7 хувь байсан бол 2024 оны 3 улирлын байдлаар 3,7 хувь болж 3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гадаадын хөрөнгө оруулалтаар орон нутагтаа төсөл хэрэгжүүлэх боломж бүрдүүлсэн. Жайка Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй Зорилтод бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төслийг 2025 оноос эхэн Дундговь аймагтаа зохион байгуулахаар ажиллаж байна. Туршилтаар хэрэгжиж буй төслийн хүрээнд Сайнцагаан сумын 4 иргэнийг сонгон авч бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлж харилцаа хандлага өөрчлөх сургалтад хамруулж, ажлын байранд дадлагажуулан

ажиллуулснаар зорилтод бүлгийн 3 иргэн байнгын ажлын байранд зуучлагдаж, 1 иргэн хувиараа хөдөлмөр эрхлэхээр ажлын байрны түрээсийн гэрээгээ байгуулах шатандаа явж байна.



Дундговь аймаг Засаг даргын Тамгын газраас 15 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн, ЕБС-ийн ахлан ангийн сурагчдын дунд "MINI START UP"-2024 төслийн уралдааныг амжилттай зохион байгуулж, 11 багийн 55 хүүхэд оролцлоо. Тус уралдаан нь 3 долоо хоногийн хөтөлбөрөөр явагдаж, шилдэг 3 багийг шалгаруулж, баг тус бүрт гарааны хөрөнгө 2,0 сая төгрөгийн батламжийг гардуулсан.




Мөн Хүнс хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, "Галт билэг" тогоочдын холбоотой хамтран тогооч, зөөгч бармены мэргэжлийн сургалтыг 7 аж ахуй нэгж байгууллагын ажилгүйдэлд өртөж болзошгүй 59 ажилтан, ажилгүй 3 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэн, нийт 65 иргэнийг хамруулан зохион байгуулж, 25 сая төгрөг зарцуулан ажилласны үр дүнд тогооч, зөөгч, бармены мэргэжил олгох сургалтад хамрагдсан 65 иргэн тогтвортой байнгын ажлын байраар хангагдсан байна.



Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

2024 онд нийт 41 ажил олгогчийг нийгмийн даатгалд шинээр хамруулж нийт 568 аж ахуйн нэгж байгууллага хамрагдаж өмнөх оноос 6,7% нэмэгдүүлэн ажилласан байна. Албан журмын даатгалд шинээр 175 даатгуулагч буюу нийт 7169 даатгуулагч хамруулахаас шинээр 183 даатгуулагч нийт 7177 даатгуулагчийг хамруулсан байна. Хамралт өмнөх онтой харьцуулахад 100.1 хувьтай байна.



Сайн дурын даатгуулагчдын хамралтын талаар

Ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа иргэдтэй холбогдон шимтгэл нь тасрахаас сэргийлж сайн дураар шимтгэл төлөхийг санал болгон ажилласан. Хөдөлмөр хөлөмж үйлчилгээний газраас 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа асран хамгаалагчийн мэдээллийг аван холбогдож хуулиа сурталчлан шимтгэл төлүүлсэн. 2024 онд сайн дурын даатгалд 4684 даатгуулагч хамрагдсан.

2024 оны 01 сараас Сайн дурын даатгуулагчдын малчны шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс төлөх дүнгээс тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50%-ийг улсын төсвөөс төлөх шийдвэр гарсаныг малчиадад сурталчлан 2805 малчин даатгуулагчийг хамруулсан байна.

Д/Д	Төрөл	2023 он	2024 онд хамруулах төлөвлөгөө	2024.10.14 байдлаар	Биелэлтийн хувь
	Нийт сайн дураар даатгуулагчийн тоо: Үүнээс:	4118	4662	4684	100.4%
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эцэг/эх	-	138	51	36.9%
2	0-3 насны хүүхэдтэй эх	661	760	566	74.4%
3	Малчдын тоо	2149	2342	2805	119.7%
4	Энгийн СДД	1308	1422	954	67%
	Нэгтгэл	8236	17560	26620	79 %

Энэ онд шинээр 544 сайн дурын даатгуулагч хамруулахаас 583-г хамруулж төлөвлөгөөг 107,2% -иар биелүүлсэн байна.


Нийт сайн дураар даатгуулагчдын эзлэх хувь

■ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг/эх

■ 0-3 насны хүүхэдтэй эх

■ малчин/туслах малчин

■ Энгийн сайн дурын даатгал



Малчин, ххэ нарт сургалт зохион байгуулах

Иргэд олон нийтэд хууль тогтоомж таниулан сурталчлах, хамралтыг нэмэгдүүлэх" ажлын хүрээнд 15 сумын засаг даргын тамгын газартай хамтран баг нийтийн иргэдийн хурал болон малчны зөвлөгөөнд оролцон 23 удаагийн сургалтад 26 багийн 2039 иргэд даатгуулагчид мэдээлэл хүргэн ажилласан.




Шинэчлэгдсэн хууль тогтоомж таниулан сурталчлах,

“Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн ач холбогдлыг ажил олгогч, даатгуулагч, иргэдэд сурталчлах, мэдээлэл өгөх, зөвлөн туслах үйлчилгээг идэвхижүүлэх зорилгоор 12 суманд нээлттэй хаалганы өдөрлөг, 36 ажил олгогчдод сургалт зохион байгуулж, мөн багийн нийтийн хурал, уулзалт ярианд 6710 иргэд даатгуулагч нарт мэдээлэл хүргэн ажилласан ажилласан.



Зарцуулсан хөрөнгийн хэмжээг салбараар харуулбал:



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 92,5 хувь буюу “Тодорхой үр дүнд” хүрсэн гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Байнгын ажлын байранд 567, түр ажлын байранд 625, нийт 1192 иргэнийг ажилд зуучилж, үүнээс 312 шинэ ажлын байр бий болгосон. Аймгийн хэмжээнд 2023 оны статистик мэдээгээр 1487 ажилгүй иргэн байгаагаас 567 иргэн байнгын ажилд зуучлагдсан нь ажилгүй иргэдийн 38.1 хувийг эзэлж байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдтай байгуулсан гэрээний үүргийг хэрэгжүүлэхийн тулд 5,496.6 тэр бум төгрөгийн санхүүжилтийг зарцуулснаас орон нутгийн төсвөөс 782.9 сая төгрөгийг зарцуулж гэрээгээр хүлээсэн үүргийг үр дүнтэй хэрэгжүүлсэн гэж дүгнэлээ.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт төлөвлөж, хэрэгжүүлэх” гэсэн арга хэмжээг энэ онд 8 үйлдвэрлэлийн осол гарснаас Эрүүл мэндийн салбарт ажил үүргээ гүйцэтгэж байхдаа 3 алба хаагч үйлдвэрийн осолд өртсөн. Мөн аймгийн аж ахуйн нэгж дээр 4 үйлдвэрийн осол гарсан байна. Мөн аймгийн газар нутгаар дамжин өнгөрөх явцад 1 осол гарсан боловч дээд газарт манай аймагт болсон ослоор актыг хянаж баталгаажуулсан байна.

Иймээс хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн зүгээс жил бүр төлөвлөгөөт хяналт хийн гарсан зөрчлийг арилгуулж байгаа боловч албан хаагч, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа мөрдөөгүй, анхаарал болгоомжгүй хүчин зүйлсээс шалтгаалсан гэж үзэж болохоор байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Нийгмийн бодлогын хэлтэст :

1. Гэрээнд тусгагдсан үүргийн хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө суурь түвшин, хүрэх түвшин бодитой судалгаанд үндэслэн тодорхойлох талаар яамандаа уламжлах

2. Гэрээний хэрэгжилтийн тайланг ирүүлэхдээ шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшиндээ хүрсэн эсэх гарсан эцсийн үр нөлөөг тайлagnаж байх

3. Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахдаа үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон боловсруулж оны эхэнд ineggee.gov.mn төрийн мэдээллийн цахим системд оруулж баталгаажуулах

4. Гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан агентлагуудыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, арга хэмжээний хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн Засаг даргыг тогтмол мэдээллээр хангаж байх

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга

С.Мөнхчулуун

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн

дарга

Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний

Хэлтсийн мэргэжилтэн

Л.Мягмармядаг

Хулд Эрүүл мэндийн төвийн бага эмч алсын дуудлаганд ажил үүргээ гүйцэтгэж байгаад авто машины донсолгоонд нуруундаа хүнд гэмтээсэн 1 ослын акт баталгаажуулсан. 2. Аймгийн төвийн Нэгдсэн эмнэлгийн жолооч Улаанбаатар хотоос хүчилтөрөгчийн баллон тээвэрлэх албан томилолттой ажил гүйцэтгэж байгаад халтирч унаад ахир сүүлээ хугалсан 1 ослын актыг хянаж баталгаажуулсан. 3. Мөн Нэгдсэн эмнэлгийн үйлчлэгч цэвэрлэгээний ажил үүргээ гүйцэтгэж байхдаа шилэн хаалга мөргөж нүд, нүүрээ гэмтээсэн 1 ослын актыг хянаж баталгаажуулсан. 4. Улаанбаатар хотын Лэнд тест ХХК-ий өрмийн туслах жолооч Дундговь аймгийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт машины засварын ажил үүрэг гүйцэтгэж байх явцдаа автомашины доогуур цээжин биенийхээ хэсгээр дайрагдаж хүнд гэмтсэн 1 ослын актыг хянаж баталгаажуулсан. 5. Соёолон интернэшнл ХХК-ийн Салхит баяжуулах 2-р үйлдвэрийн төслийн ахлах цахилгаанчин 23 дугаар камерийн хөдөлгүүрт хүчдэл, реминэн дамжуулгад үзлэг хийж явахдаа зүүн гарaa хавчуулан гэмтээж, хүнд гэмтсэн 1 ослын актыг хянаж баталгаажуулсан. 6.Хосжирэм ХХК-ийн цахилгаанчин Ерлөг дэд станцын Т2 талд хаалттай хуваарилах байгууламж дээр ячейкнуудад цэвэрлэгээ үйлчилгээ хийх, трансформаторын тосны түвшинг шалгах ажлыг гүйцэтгэж байхдаа хүчдэлд нэрвэгдэж 2 гарaa түлсэн 1 ослын актыг хянаж баталгаажуулсан. 7. Ган-Илч ХХК-ийн гагнуурчин засварын байрандаа ажил үүргээ гүйцэтгэж байгаад халтирч унаад гарaa гэмтээсэн 1 ослын актыг хянаж баталгаажуулсан.

[3:10 PM] Мягмармядаг 88977988:

Эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, удаашралтай болон тасарч болзошгүй ... заалтын жагсаалтыг гарган хэлтэс, агентлагуудад хүргүүлэн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар явцын хяналт-шинжилгээгээр агентлаг бүрд зөвлөгөө өгч ажилласны үр дүнд хийсэн ажлын үр дүн ахисан үзүүлэлттэй байна.